



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянасан нийцлийн аудитын (НТАГ-2023/51-19-ШТА-НА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитын үр дүнг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлэхийг Аудитын удирдлага зохицуулалтын хэлтэс (Д.Ичин)-т үүрэг болгосугай.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх

АУДИТЫН КОД: НТАГ-2023/51-19-ШТА-НА

Аудитын удирдлага зохицуулалтын
хэлтэс

Хэлтсийн дарга,
аудитын менежер:

Ахлах аудитор:

Д.Ичин

С.Лхагвасүрэн

Улаанбаатар хот
2023 он

Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө Г корпус
424 дүгээр өрөө. Утас 315578

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас [http: //niislel.audit.mn/](http://niislel.audit.mn/)

АГУУЛГА

| | |
|---|---|
| Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын тушаал | 1 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл | 3 |
| ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | 4 |
| БҮЛЭГ 1. Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн болон дахин сонгуульд нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт, зарцуулалт | 5 |
| БҮЛЭГ 2. Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн болон дахин сонгуульд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх | 6 |
| Аудитын дүгнэлт | 6 |
| Хавсралтууд | 7 |

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.3-д заасан Нийслэл дэх Төрийн аудитын газрын бүрэн эрх, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/22 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын дүнг олон нийтэд мэдээлнэ.

Аудитын хамрах хүрээ

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон улс төрийн нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамруулсан.

Аудитын арга зүй

Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд MNS 6817 : 2020 - Төрийн аудитын стандартын дагуу гүйцэтгэв.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам

Аудит хийх бүрэлдэхүүн

Аудитыг аудитын удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга, аудитын менежер Д.Ичин хянан удирдаж, ахлах аудитор С.Лхагвасүрэн нар хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгуульд 3 намын 3 нэр дэвшигч оролцохоор бүртгүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 *"Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ"* гэж заасны дагуу 3 нам иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж баталгаажуулан Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн 3 намын нэр дэвшигч нийт 43.5 сая төгрөг зарцуулснаар тайлагнасан нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5 *"Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд тусгайлан хязгаар тогтоохгүй боловч тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зардлын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй"* гэж заасантай нийцэж байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторовын 2020 оны А/33, А/34 дүгээр тушаалаар баталсан нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчийн зарцуулах зардлын дээд хэмжээг сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн нам, нэр дэвшигчид хэтрүүлээгүй байна.

Аудитын хуулийн этгээд нь Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторовын 2020 оны А/52 дугаар тушаалаар баталсан "Сонгуулийн зардлын тайлан гаргах маягт"-ын дагуу нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг гаргаж, баталгаажуулжээ.

БҮЛЭГ 1. Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн болон дахин сонгуульд нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт, зарцуулалт

Нийслэл дэх Төрийн аудитын газарт Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3. “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу 3 нам сонгуулийн зардлын тайлангаа баталгаажуулж ирүүлжээ.

Хүснэгт 1. Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон намаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангаарх орлого, зардал

| № | Нэр | Орлого | | Зарлага | |
|------|------------------|--------|----------|---------|----------|
| | | Тоо | Нийт | Тоо | Нийт |
| 1 | Монгол Ардын нам | 97 | 13,304.0 | 57 | 12,444.0 |
| 2 | Ардчилсан нам | 7 | 18,400.2 | 4 | 18,400.2 |
| 3 | ХҮН нам | 67 | 12,693.0 | 37 | 12,693.0 |
| Нийт | | 171 | 44,397.2 | 98 | 43,537.2 |

/ мян/төг/

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон намуудаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 44,397.2 мянган төгрөг байна.

Сонгуулийн зардлын тайланд иргэний нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу гэсэн шалтгаанаар 3,270.0 мянган төгрөгийн хандивыг буцаасан байна.

Сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 43,537.2 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 25,846.4 мянган, бусад зардалд 17,690.8 мянган төгрөг зарцуулжээ.

БҮЛЭГ 2. Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн болон дахин сонгуульд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1. *“Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ”* гэж заасан.

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд иргэн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн 23,150.0 мянган төгрөгийн хандив өгсөн байна.

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон нэр дэвшигчдэд 15 иргэн 23,150.0 мянган төгрөгийн хандив өгсөн нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1. *“Мөнгөн хандив иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэл байна.”* гэсэн заалттай нийцэж байна.

Нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн нэрсийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралтаар харуулав. /Хавсралт1/

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд нам, нэр дэвшигчдийн 3 зардлын тайланд аудитын хуулийн этгээдүүд үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн дүгнэлт өгсөн байна.

3. Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд нийт 44,397.2 мянган төгрөг төвлөрч сонгуулийн үйл ажиллагаанд 43,537.2 мянган төгрөг зарцуулжээ.

4. Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд иргэнээс өгсөн хандиваас иргэний нэр, регистрийн дугааргүй, хуулиар тогтоосон хязгаараас илүү хандивласан гэсэн шалтгаанаар 9 иргэний 3,270.0 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлжээ.

6. Орон нутгийн хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцсон 3 намын нэр дэвшигчдэд нийт 23,150.0 мянган төгрөгийн хандив өгснийг хянаж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дахь заалтын дагуу олон нийтэд мэдээлэв.

Сүхбаатар дүүргийн ИТХ-ын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдэд 1 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн этгээдийн жагсаалт

| № | Хандивлагчийн нэр | Иргэн хуулийн этгээд | Хандивын хэмжээ /төгрөг/ | Хандивласан огноо |
|-----|-------------------|----------------------|--------------------------|-------------------|
| 1 | Д.Ариунболд | Иргэн | 1,000,000 | 2023.05.31 |
| 2 | Д.Хүлэг-Эрдэнэ | Иргэн | 2,000,000 | 2023.05.31 |
| 3 | Б.Алтанзагас | Иргэн | 2,000,000 | 2023.05.31 |
| 4 | Г.Хас-Эрдэнэ | Иргэн | 1,000,000 | 2023.05.31 |
| 5 | Г.Тэлмэн | Иргэн | 1,000,000 | 2023.06.06 |
| 6 | А.Ганхуяг | Иргэн | 1,000,000 | 2023.06.07 |
| 7 | Б.Амартүвшин | Иргэн | 2,000,000 | 2023.06.12 |
| 8 | Д.Баярсайхан | Иргэн | 2,000,000 | 2023.06.12 |
| 9 | П.Тэмүүжин | Иргэн | 2,000,000 | 2023.06.14 |
| 10 | Н.Дорждагва | Иргэн | 2,000,000 | 2023.06.14 |
| 11 | Г.Даваабаяр | Иргэн | 2,000,000 | 2023.06.14 |
| 12 | Г.Дондог | Иргэн | 1,650,000 | 2023.06.14 |
| 13 | Т.Доржханд | Иргэн | 1,000,000 | 2023.06.02 |
| 14 | н.Лхагвасүрэн | Иргэн | 1,500,000 | 2023.06.02 |
| 15 | Ш.Отгонтуяа | Иргэн | 1,000,000 | 2023.06.02 |
| Дүн | | | 23,150,000 | |